



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/37

Шивээговь сум

Сумын 2024 оны газар зохион байгуулалтын
тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2, 25 дугаар зүйлийн 25.1.4, 25.4, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2024 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | |
|-----------------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч: | Засаг даргын орлогч |
| Гишүүд: | Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | 1 дүгээр багийн Засаг дарга |
| | 2 дугаар багийн Засаг дарга |
| | Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга: | Газрын даамал |

2. Хот тосгон бусад суурины газрыг эзэмшүүлэх, ашиглуулах төлөвлөгөө боловсруулах, бэлчээрийн газрын даац тогтоох, бэлчээрийн сэлгээ хийх, хамгаалах, бэлчээрийг сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх, малчдын өвөлжөө, хаваржааны газрыг төлөвлөх, суурь судалгааг боловсруулахыг (Ажлын хэсэг)-т үүрэг болгосугай.

3. 2024 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, ажлын явцыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг (Ажлын хэсгийн ахлагч)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  П. ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 27-ний өдрийн
11/37 тоот захирамжийн хавсралт

Сумын 2024 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн
төлөвлөгөө боловсруулах ажлын удирдамж

1.Зорилго: Сумын газар нутгийн хэмжээнд хэчнээн хэмжээний газрыг хаана, ямар зориулалтаар эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх нөөц боломжийг тодорхойлсны үндсэн дээр зүй зохистой, оновчтой, бүрэн дүүрэн ашиглалтыг буй болгох зураг төслийн аргаар тодорхойлсон баримт бичгийг боловсруулахад оршино.

2. Хэрэгжүүлэх хугацаа: Газрын тухай хуулийн 25.4-т зааснаар тухайн жилийн төлөвлөгөөг жилдээ хэрэгжүүлэх бөгөөд 2024.01.01-2024.12.01 хүртэл

3. Баримтлах чиглэл, зарчим: Тухайн жилийн төлөвлөгөөний хүрээнд дараах үндсэн асуудлыг шийдвэрлэнэ.

3.1 Газар ашиглагч, эзэмшигч өмчлөгчдийн газрын оновчтой, зөв зохистой хэмжээ, бүтцийг нь тогтоож эрх зүйн баталгааг хангахын тулд тухайн жилд өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил хэмжээг тогтоох

3.2 Тухайн жилийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглалтын асуудлыг орон нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлалтай уялдуулан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн хуваарийн дагуу зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг тусган арга хэмжээг зохион байгуулах, хадлангийн талбайг хамгаалах, сайжруулах арга хэмжээг төлөвлөх.

3.3 Газрыг уул уурхайн болон бусад төрлийн элэгдэл, эвдрэл, бохирдолт, цөлжилтөөс хамгаалах, сэргээн сайжруулах, байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалах, элэгдсэн болон эвдэрсэн газрыг нөхөн сэргээхтэй холбогдсон арга хэмжээнүүдийг авах.

3.4 Усан сан болон ойн зурвас байгуулах газрыг оновчтой дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдуулах.

3.5 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг Орон нутгийн хөгжлийн санд төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулах.

3.6 Газар ашиглалтын төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор доороос нь дээш нь чиглэсэн, хэрэгжих магадлалтай боловсруулсан байна.

3.7 Тухайн жилийн төлөвлөгөө нь иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, нөхөн сэргээхэд болон зураг төсөл, төлөвлөлт, зохион байгуулах ажилд тулгуур материал болгон ашиглана.

4. Тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах дараалал, түүнийг баталгаажуулах:

4.1 Сумын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах удирдамжийг боловсруулан сумын Засаг даргаар батлуулах

4.2 Сумын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах удирдамжийг 1,2 дугаар багийн иргэд, малчдын нөхөрлөл, бүлгүүдэд хүргэх ойлгуулах

4.3 Сумын 2 дугаар багийн газар нутгаар ажлын хэсэг маршрут гарган хэмжилт хийн, Бэлчээрийн даацыг тодорхойлсон хээрийн судалгааг боловсруулах

4.4 Аж ахуй нэгж, байгууллага, багийн иргэд, малчдын бүлэг, нөхөрлөлөөс “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-нд оруулах саналыг авах.

4.5 Бэлчээр ашиглалтын хэсэгт хамрагдаж байгаа малчид бэлчээрээ өнжөөж амраах, сэргэж ашиглах, усжуулах, отор нүүдэл хийх, бэлчээрээ хамгаалах талаар малчдад ухуулга сурталчилгаа хийж малчидтай зөвшилцөнө.

4.6 Барилга байгууламжийн дэвсгэр газар болон, бэлчээр ашиглалтын хэсэг, өвөлжөө, хаваржаа, худаг уст цэг, хадлан тариалан, бэлчээрийг өнжөөж сэлгэх хамгаалах зэрэг судалгаа бичмэл тайлангаа зурган хэвлэлд хөрвүүлэх.

4.7 Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний төслийг зураглалын хамт сумын Засаг даргад өргөн мэдүүлнэ.

4.8 Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг 2024 оны орон нутгийн хөгжлийн санд төлөвлөж тусгуулах.

5. Ажлын үе шат:

5.1 Бэлтгэл үе шат

5.2 Хээрийн судалгаа хийж, төлөвлөх үе шат

5.3 Тухайн жилийн “Газар зохион байгуулалт” цаашид авах арга хэмжээ, сумын хэмжээний хэлэлцүүлэг зохион байгуулах

5.4 ИААНБ-аас санал авч нэгтгэх ажлын хэсгээр хэлэлцүүлэх, Сумын ИТХ-аар батлуулах

5.5 Холбогдох зураг, хүснэгтэн баримт материал, тооцоо , тайланг бүрдүүлэх

5.6 Хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих гэсэн үе шатнаас бүрдэх ба дараах төрлийн суурь судалгаа, төлөвлөлтийн шийдлийг багтаана.

6. Гарах баримт бичиг:

6.1 Тайлан

6.2 Төлөвлөгөөний нэгдсэн зураг

6.3 Сэдэвчилсэн бусад зураг / Бэлчээрийн даац, хөрс, ургамал/

6.4 Тооцоо судалгааны тайлан / хүснэгт, диаграмм/

АЖЛЫН ХЭСЭГ